

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.6, 46.10 дугаар зүйл, “Тэнгэр Даатгал” ХК-ийн Дүрмийн 7.2 дугаар зүйл болон “Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тэнгэр Даатгал” ХК нь 2025 онд 10.56 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2025 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 114.4 төгрөг буюу нийт 6,864,000,000.00 (зургаан тэрбум найман зуун жаран дөрвөн сая) төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашгийг 2026 оны 03 сарын 31-ний өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баянмөнх)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашиг хуваарилсны дараа Компани нь төлбөрийн чадвартай байх бөгөөд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа болохыг дурдсугай.
5. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн энэхүү шийдвэрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баянмөнх)-д даалгасугай.

Энэхүү шийдвэрийг 2026 оны 02 сарын 05-ны өдөр бичгээр үйлдсэнийг гэрчлэн компанийн тухай хуулийн 80.2-р заалтыг үндэслэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.ГАНТУЯА